



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 01608

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Спорт заалны барилга (Говь-Алтай, Бугат сум)-ын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)
	Э.Пүрэвжаргал	(Барилга, хөгжлийн төвийн барилга, байгууламж захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер)
	Г.Базархүрэл	(Биеийн тамир, спортын улсын хорооны санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Ч.Дашням	(Бугат сумын Засаг дарга)
	Я.Цэрэндолгор	(Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Д.Баярчулуун	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер)	
Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)	

C:\Documents\ ZD A-4 doc

1001199

2.

- Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
Д.Жүгдэрнамжил ("Нью Таур" ХХК-ийн захирал (зохиогч)
С.Цэрэндолгор ("Аксу-Алтай" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Ш.Даваадорж ("Аксу-Алтай" ХХК-ийн инженер)
Нарийн бичгийн дарга: Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР